



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/288

Номгон

Хөдөө аж ахуйн кластерийн ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тус тус заасан “Тогтвортой хөдөө аж ахуй” зорилгын хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх, мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах цогцолбор байгуулах, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх замаар малын тэжээл, төмс, хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилгоор Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/a/ дахь заалт, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн XVII.1.12, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Аймаг орон нутагт эрх шилжүүлэх хуваарь батлах тухай” А-33 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн XVII.1.12 дугаарт батлагдсан “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн кластер байгуулах” төсөл хөтөлбөрийн хүрээнд Ингэний сүүний үйлдвэр байгуулах, Ногоон тэжээлийн үйлдвэр байгуулах, 1000 тн хүчин чадалтай мах, ногооны зоорь байгуулах, Кластер байгуулахтай холбоотой дэд бүтцийг шийдвэрлэх ажлуудыг зохион байгуулсугай.

2. Хөрөнгө оруулалтын томоохон төслүүд болон бүс, орон нутгийн хэмжээнд дээрх ажлуудын тооцоо судалгааг гаргаж холбогдох зураг төсвийг хийлгэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

3. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн XVII.1.12 дугаарт батлагдсан “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн кластер байгуулах” төслийн энэ онд

621010735


D:\2021\Zakhiramj-2021 on\Захирамж-2021 он.docx

2.


батлагдсан 3,0 тэрбум төгрөгийг дээрх 4 төрлийн төсөл, арга хэмжээнд олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Ингэний сүүний үйлдвэр байгуулах, Ногоон тэжээлийн үйлдвэр байгуулах, 1000 тн хүчин чадалтай мах, ногооны зоорь байгуулах, Кластер байгуулахтай холбоотой дэд бүтцийг шийдвэрлэх 4 төрлийн ажлуудын зохион байгуулалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Хөдөө аж ахуй, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН



0320110002  
0097342 ГСТ7121